

**БОГД БАНК ХК**

(Монгол Улсад бүртгэлтэй аж ахуй нэгж)

Санхүүгийн Хураангуй Тайлан

2023 оны 12 дугаар сарын 31



## САНХҮҮГИЙН ХУРААНГУЙ ТАЙЛАНГИЙН ТАЛААРХ ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН

### Богд Банк ХК-ийн хувьцаа эзэмшигчдэд

#### Дүгнэлт

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаарх санхүүгийн байдлын хураангуй тайлан болон тухайн жилийн ашиг алдагдал ба бусад дэлгэрэнгүй орлогын хураангуй тайлангаас бүрдсэн Санхүүгийн хураангуй тайланг Богд Банк ХК (“Банк”)–ийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлант жилийн аудитлагдсан санхүүгийн тайланд үндэслэн бэлтгэсэн болно.

Бидний дүгнэлтээр хавсралт дахь санхүүгийн хураангуй тайлангууд нь бүх материаллаг зүйлсийн хувьд “Тайлан бэлтгэх үндэслэл” тодруулгад тайлбарласны дагуу Банкны 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлант жилийн аудитлагдсан санхүүгийн тайлантай тохирч байна.

#### Санхүүгийн хураангуй тайлан

Энэхүү санхүүгийн хураангуй тайлан нь Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт (“СТОУС”)–ын шаардсан бүх тодруулгыг агуулаагүй болно. Иймд энэхүү санхүүгийн хураангуй тайлан ба аудиторын дүгнэлт нь Банкны аудитлагдсан санхүүгийн тайлан ба аудиторын дүгнэлтийг орлохгүй.

#### Аудитлагдсан санхүүгийн тайлан ба аудиторын дүгнэлт

Бид 2024 оны 3 дугаар сарын 22-ний өдөр батлагдсан аудитлагдсан санхүүгийн тайлангуудад зөрчилгүй дүгнэлт өгсөн ба уг дүгнэлтэд Аудитын онцгойлсон асуудал багтсан. Аудитын онцгойлсон асуудал нь тухайн жилийн санхүүгийн тайлангийн аудитад бидний мэргэжлийн үнэлэмжээр хамгийн өндөр ач холбогдол бүхий асуудал болох “Харилцагчдад олгосон зээл ба урьчилгааны үнэ цэнийн бууралт” байсан.

#### Санхүүгийн хураангуй тайлантай холбоотойгоор удирдлагын хүлээх хариуцлага

Санхүүгийн хураангуй тайланг “Тайлан бэлтгэх үндэслэл” тодруулгад тайлбарласны дагуу бэлтгэх нь Банкны удирдлагын хариуцлага юм.

#### Аудиторын хариуцлага

Бидний үүрэг бол шинэчлэгдсэн Аудитын олон улсын стандарт (“АОУС”) 810 буюу “Санхүүгийн хураангуй тайлангийн талаар дүгнэлт өгөх гэрээт ажил”–ын дагуу шаардсан горимуудыг гүйцэтгэж, түүндээ үндэслэн санхүүгийн хураангуй тайланд дүгнэлт өгөх явдал юм.

*Ernst & Young Mongolia Audit LLC*


ЭРНСТ ЭНД ЯНГ МОНГОЛИЯ АУДИТ ХХК  
Мэргэшсэн нягтлан бодогчид

Гарын үсэг зурсан



Мандахбаяр Доржбат  
Партнер

Баталсан



Адриан Чу  
Партнер

Улаанбаатар хот, Монгол Улс  
Огноо: 2024 оны 3 дугаар сарын 22

**Богд Банк ХК**  
**2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон**  
**Ашиг Алдагдал ба Бусад Дэлгэрэнгүй Орлогын Хураангуй Тайлан**

	2023 Мян.төг	2022 Мян.төг
Хүү болон түүнтэй адилтгах орлого	82,562,314	45,611,503
Хүү болон түүнтэй адилтгах зардал	(42,345,797)	(16,258,468)
<b>Хүүний цэвэр орлого</b>	<b>40,216,517</b>	<b>29,353,035</b>
Шимтгэл, хураамжийн орлого	4,098,026	2,121,638
Шимтгэл, хураамжийн зардал	(1,323,828)	(602,073)
<b>Шимтгэл, хураамжийн цэвэр орлого</b>	<b>2,774,198</b>	<b>1,519,565</b>
Арилжааны цэвэр орлого	701,775	2,044,326
Үйл ажиллагааны бусад орлого	1,688,216	1,220,937
<b>Нийт үйл ажиллагааны орлого</b>	<b>45,380,706</b>	<b>34,137,863</b>
Хүлээгдэж буй үнэ цэнийн бууралтын алдагдлын зардал	(847,011)	(517,855)
<b>Үйл ажиллагааны цэвэр орлого</b>	<b>44,533,695</b>	<b>33,620,008</b>
Үйл ажиллагааны зардал	(13,100,166)	(12,393,928)
<b>Татварын өмнөх ашиг</b>	<b>31,433,529</b>	<b>21,226,080</b>
Орлогын албан татварын зардал	(3,232,146)	(2,169,603)
<b>Тайлант жилийн ашиг</b>	<b>28,201,383</b>	<b>19,056,477</b>
<b>Бусад дэлгэрэнгүй орлого/(алдагдал) (татварын дараах):</b>		
Дараагийн тайлант хугацаанд ашиг, алдагдлын тайлан руу дахин ангилагдах бусад дэлгэрэнгүй орлого (татварын дараах):		
<i>Бодит үнэ цэнийн өөрчлөлтийг бусад дэлгэрэнгүй орлогын тайланд бүртгэдэг өрийн хэрэглүүрийн дахин үнэлгээний өөрчлөлт</i>	3,816,507	(5,030,295)
<i>Ашиг алдагдлын тайлан руу дахин ангилагдах өрийн хэрэглүүрийн олз/(гарз)</i>	(462,025)	2,502,234
Дараагийн тайлант хугацаанд ашиг, алдагдлын тайлан руу дахин ангилагдахгүй бусад дэлгэрэнгүй орлого:		
<i>Бодит үнэ цэнийн өөрчлөлтийг бусад дэлгэрэнгүй орлогын тайланд бүртгэдэг өмчийн хэрэглүүрийн дахин үнэлгээний өөрчлөлт</i>	—	(500,000)
<b>Бусад дэлгэрэнгүй орлого/(алдагдал)</b>	<b>3,354,482</b>	<b>(3,028,061)</b>
<b>Тайлант жилийн татварын дараах нийт дэлгэрэнгүй орлого</b>	<b>31,555,865</b>	<b>16,028,416</b>

**Нэгж хувьцааны ашиг (Төгрөг):**

Нэгж хувьцаанд ноогдох суурь болон хорогдуулсан ашиг 22.56 15.25

2024 оны 3 дугаар сарын 22-ний өдөр Төлөөлөн Удирдах Зөвлөлөөс олгосон эрхийн дагуу энэхүү тайланг нийтлэхийг зөвшөөрч, гарын үсэг зурав.

**Ганбаатарын Саруул**

Гүйцэтгэх захирал

*Тайлан бэлтгэх үндэслэл. Санхүүгийн хураангуй тайланг СТОУС-ын дагуу бэлтгэсэн Банкны аудитлагдсан санхүүгийн тайлан дахь Санхүүгийн байдлын тайлан болон Ашиг алдагдал ба бусад дэлгэрэнгүй орлогын тайлангуудыг өөрчлөлгүйгээр хураангуйлан бэлтгэсэн болно.*

**Молормжамцын Бат-Өлзий**

Санхүү хариуцсан захирал

**Богд Банк ХК**  
**2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон**  
**Санхүүгийн Байдлын Хураангуй Тайлан**

	2023 оны 12 сарын 31 Мян.төг	2022 оны 12 сарын 31 Мян.төг
<b>ХӨРӨНГӨ</b>		
Бэлэн мөнгө ба Монголбанкинд байршуулсан мөнгө	154,951,119	127,975,910
Бусад банк, санхүүгийн байгууллагад байршуулсан мөнгө	60,656,693	51,241,913
Санхүүгийн хөрөнгө оруулалт	131,805,575	69,625,463
Үүсмэл санхүүгийн хэрэглүүр	723,943	433,677
Харилцагчдад олгосон зээл ба урьдчилгаа	312,151,051	208,605,193
Бусад хөрөнгө	17,847,674	11,143,051
Борлуулах зорилготой хөрөнгө	25,823,929	1,468,263
Үндсэн хөрөнгө	4,319,141	4,197,543
Ашиглах эрхтэй хөрөнгө	3,086,677	2,760,642
Биет бус хөрөнгө	958,579	931,856
<b>НИЙТ ХӨРӨНГӨ</b>	<b>712,324,381</b>	<b>478,383,511</b>
<b>ӨР ТӨЛБӨР</b>		
Бусад банк, санхүүгийн байгууллагын харилцах, хадгаламж	16,112,969	43,347,904
Буцаан худалдан авах хэлцэл	50,471,858	65,471,192
Харилцагчдын харилцах, хадгаламж	362,511,074	217,242,434
Үүсмэл санхүүгийн хэрэглүүр	1,658,530	62,118
Зээлийн санхүүжилт	128,957,763	27,137,624
Бусад өр төлбөр	6,429,984	4,333,099
Түрээсийн өр төлбөр	3,409,558	2,955,777
Орлогын татварын өглөг	1,159,202	1,213,285
<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>570,710,938</b>	<b>361,763,433</b>
<b>ЭЗДИЙН ӨМЧ</b>		
Хувьцаат капитал	98,556,822	98,556,822
Бусад нөөц сан	1,830,472	(1,579,154)
Хуримтлагдсан ашиг	41,226,149	19,642,410
<b>НИЙТ ЭЗДИЙН ӨМЧ</b>	<b>141,613,443</b>	<b>116,620,078</b>
<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ</b>	<b>712,324,381</b>	<b>478,383,511</b>

2024 оны 3 дугаар сарын 22-ний өдөр Төлөөлөн Удирдах Зөвлөлөөс олгосон эрхийн дагуу энэхүү тайланг нийтлэхийг зөвшөөрч, гарын үсэг зурав.

**Ганбаатарын Саруул**  
Гүйцэтгэх захирал



**Моломжамцын Бат-Өлзий**  
Санхүү хариуцсан захирал

*Тайлан бэлтгэх үндэслэл. Санхүүгийн хураангуй тайланг СТОУС-ын дагуу бэлтгэсэн Банкны аудитлагдсан санхүүгийн тайлан дахь Санхүүгийн байдлын тайлан болон Ашиг алдагдал ба бусад дэлгэрэнгүй орлогын тайлангуудыг өөрчлөлгүйгээр хураангуйлан бэлтгэсэн болно.*

